

1. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

Статистикийн хэлтэс нь Монгол Улсын хууль, тогтоомжоор тогтоосон үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх, өмчлөгчийн үйл ажиллагааны чиглэлээ хангах үүднээс дараах стратегийн гол зорилтыг эн тэргүүнд тавьж ажиллахаар төлөвлөв.

3.1 Байгууллагын алсын хараа

- Статистикийн албаны өндөр ур чадвар бүхий идэвхтэй, санаачлагатай менежер-манлайлагчид
- Статистикийн үйл ажиллагааг хэрэглэгч, иргэдэд чиглэсэн уян хатан бодлого
- Мэдлэг чадвартай, мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагчид
- Статистикийн үйл ажиллагааны чадавхи сайтай, тасралтгүй суралцаж, хөгжиж байгаа төрийн захиргааны оновчтой алба,
- Иргэдийн хүсэн хүлээж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн үр дүнд чиглэсэн төрийн ажил үйлчилгээний бүтээмж, чанар, хүртээмжийн өндөр түвшин

3.2 Байгууллагын хүрэх үр дүн

ЭРХЭМ ЗОРИЛГО

Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаархи шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино.

Статистикийн үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх гол чиглэлүүд:

1. Хэрэглэгчдийн өсч, өөрчлөгдөж байдаг эрэлт хэрэгцээнд уян хатан зохицох чадвартай, улсын болон олон улсын түвшинд харьцуулах боломжтой, олон улсын стандартад нийцсэн статистикийн мэдээллийн үзүүлэлтийг бүрдүүлэх
2. Статистикийн мэдээллийн чанарын удирдлага, мэргэжлийн хяналтын тогтолцоог бий болгох
3. Мэдээллийн технологийг хөгжүүлэх
4. Хүний нөөцийг хөгжүүлэх, өндөр боловсролтой, сайн сургасан боловсон хүчнийг бэлтгэж, орон нутгийн статистикийн албыг хангах,
5. Статистикийн судалгаа шинжилгээний ажлын түвшинг дээшлүүлэх, судалгаа шинжилгээний чадавхийг бий болгох
6. Статистикийн нэгжийн бизнесийн регистрийн сан байгуулж хөтлөх, мэдээллийн сан сүлжээг байгуулж, ажиллуулах
7. Мэдээлэл тархаах үйл ажиллагааг боловсронгуй болгож хөгжүүлэх

Хүрэх үр дүн

Статистикийн хэлтэс нь 2013- 2016 онд дараах үр дүнд хүрэх зорилт тавьж байна. Үүнд:

- **Хүрэх үр дүн 1** – Албан ёсны статистикийн бүх үйл ажиллагааг аймгийн төвшинд төвлөрүүлэн зохицуулж, статистикийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгож мөрдүүлэх
 - **Хүрэх үр дүн 2** – Мэдээллийн чанар, зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулан, ил тод байдлыг ханган, мэдээллийг улсын болон олон улсын стандартын түвшинд боловсруулж, тархаах
-